

АГААРЖУУЛАЛТЫН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ШИНЭ СТАНДАРТЫГ БАТАЛСАН НЬ УУР АМЬСГАЛД ЭЭЛТЭЙ ХӨРГӨЛТИЙН ХУВЬД ЧУХАЛ ҮЕ ШАТ БОЛЖ БАЙНА

АХУЙН ХЭРЭГЛЭЭНИЙ ЦАХИЛГААН ДУЛААНЫ НАСОС, АГААРЖУУЛАГЧ БОЛОН АГААР ЧИЙГШҮҮЛЭГЧИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ШААРДЛАГЫН ОЛОН УЛСЫН СТАНДАРТЫГ БАТАЛСНААР ЦЭВЭР, ТОГТВОРТОЙ ХӨРГӨЛТИЙН ХЭТИЙН ТӨЛӨВТ ТОМООХОН АХИЦ ДЭВШИЛ АВЧРАВ.

Олон улсын цахилгаан техникийн комисс (IEC)-оос баталсан шинэ стандартад гэр ахуйн технологид пропан (R290) болон бусад шатамхай хөргөх бодис зэрэг нүүрсустөрөгчийн хэмжээний дээд хязгаарыг зөвшөөрч байгаа бөгөөд энэ нь эргээд уур амьсгалд сөрөг нөлөө үзүүлэх хөргөх бодисын хийн ялгаралтыг их хэмжээгээр бууруулах боломжтой гэсэн үг юм.



Нүүрсустөрөгчийн төрлийн бодисууд нь эдийн засагт хэмнэлттэй, уур амьсгалд ээлтэй хөргөх бодис боловч шатамхай шинж чанараасаа болж маш бага хэмжээгээр хөргөлтийн төхөөрөмжид ашиглахаар хязгаарлагдсан байдаг.

Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ (БОНБУ)-ний Уур амьсгалын кампанит ажлын дарга Клэр Перри "Олон жилийн турш Засгийн газар болон үйлдвэрүүдийг энэ асуудлыг шийдвэрлэхийг уриалсны эцэст Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ (БОНБУ) нь цэвэр-тэг болон цэвэр-тогтвортой хөргөлт рүү чиглэж буй энэ үед чухал үе шатанд хүрсэнд баяртай байгаа талаар илэрхийлэв.

Энэ шинэчилсэн стандарт нь хараахан цаг үеэ олоогүй байж болох юм. Монреалийн Протоколд оруулсан Кигалийн нэмэлт, өөрчлөлтийн дагуу дэлхий нийт уур амьсгалд сөргөөр нөлөөлж буй гидрофторт нүүрсустөрөгчийг (ГФН/НFC) үе шаттайгаар бууруулж байгаа бөгөөд бид байгаль орчин болон хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлдэг гидрофторолефин (HFO) зэрэг байгалийн хийн үйлдвэрийн худалдан авах зальд орохгүйн тулд пропан (R290) гэх мэт ирээдүйд баталгаатай, хэмнэлттэй шийдлүүдийг яаралтай хэрэгжүүлж дасан зохицуулах шаардлагатай байна.

Шинэ стандартын тусламжтайгаар Европын парламент болон ЕХ-ны гишүүн орнууд агааржуулагч, дулааны насосын зах зээлийн дийлэнх хэсэгт гидрофторт нүүрсустөрөгч (ГФН/НFC)-ийн төрлийн бодис шаардлагагүй болсон гэдгийг хүлээн зөвшөөрч, ЕХ-ны санал болгож буй F-хийн зохицуулалтыг зохих журмын дагуу бэхжүүлэхийг бид хүлээж байна.

Өөрчлөлтийг батлах зургаан жил хагасын шаргуу үйл явцын дараа 04 сарын 29-ний өдөр албан ёсоор "IEC 60335-2-40" нэрлэгдсэн шинэ стандартын эцсийн төслийг баталлаа.



Аюулгүй байдлын стандартыг шинэчлэн боловсруулж, батлуулсан Олон улсын цахилгаан техникийн комисс (IEC)-ийн холбогдох ажлын хэсгийн төлөөлөгч Асбьорн Вонсилд "өмнөх хувилбарт R-290 (пропан)-ийг ашиглахыг хориглож байсан бол "IEC 60335-2-40"-ийн шинэ хэвлэл нь олон агааржуулагч, дулааны насосын системд R-290 (пропан)-ийг ашиглах боломжийг олгоно" гэдгийг нэмж дурдав.



Дээрх бодис нь R410A ашигладаг төхөөрөмжүүдтэй харьцуулахад хүлэмжийн хийн ялгаруулалтыг мянга дахин бууруулах боломжийг олгох юм. Аюулгүй байдлын шинэчилсэн стандарт нь шатамхай бус хөргөх бодис ашигладаг төхөөрөмжийн адилаар өндөр түвшний аюулгүй байдлыг хангахын тулд аюулгүй байдлын зарим нэмэлт шаардлагын дагуу хийгдсэн шинэ төхөөрөмжид илүү их хэмжээний шатамхай хөргөх бодис (стандарт агааржуулагч төхөөрөмжид R290 хөргөх бодис 988 гр хүртэл) ашиглах боломжийг олгож байна.

Энэхүү шинэ стандартыг 06 сарын 24-ний өдөр зарлах төлөвтэй байна. Үүний дараа улс орнууд үндэсний хууль, тогтоомжид яаралтай нэмэлт, өөрчлөлт оруулан батлах шаардлагатай болох юм.